



Мэдээллийн систем болон мэдээллийн эх үүсвэрүүдэд үнэлгээ хийх үйл явц, ашиглах аргачлал

Дэвид Анандэйл

2018 оны 3 сарын 26-28

Мэдээллийн системүүд болон, мэдээллийн эх үүсвэрүүдийг үнэлж үзээд СНСМС-тэй хэрхэн холбож болох талаар авч үзэх нь

2011 онд Дурбанд болсон НҮБУАӨСК-ийн Талуудын бага хурлаар СНСМС-ийн талаарх удирдамжийг баталсан. Уг удирдамжийн сүүлийн хоёр заалтад:

- “СНСМС-ийг тухайн улс өөрөө бүрэн гаргаж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.”
- “Одоогийн байгаа мэдээллийн эх үүсвэрүүд дээр суурилсан байх” гэсэн байна.

Ерөнхий танилцуулга

- Аль ч улс оронд янз бүрийн мэдээллийн систем, эх үүсвэр байдаг бөгөөд тэдгээрийг ашиглаад Канкуны зарчмуудын эрхзүйн орчин, хэрэгжилтийн талаар мэдээлэл, тайлан бэлтгэж болдог.
- СНСМС-ийг төлөвлөхийн өмнө эхлээд ийм мэдээллийн системүүдийг судалж, үнэлэх нь зүйтэй. Үүнд дараах хоёр зүйлийг хамруулж авч үздэг:
 - СНСЗ-уудтай холбоотой мэдээллийг цуглуулдаг дотоодын мэдээллийн систем, эх үүсвэрүүд
 - Тухайн улсын зүгээс нэгдэн орсон олон улсын конвенц, гэрээний дагуу тайлан хүргүүлдэг механизмууд гэх мэт.

Мэдээллийн систем, эх үүсвэрийн жишээ (Ерөнхий)

- Улсын хүн амын тооллогын мэдээ
- Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)
- Үндэсний ойн тооллого (YOT)
- Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа (ӨАТТС)
- Тогтвортой ойн аж ахуй, хөдөө аж ахуйн хэрэглээний стандарт (аудитын тайланг оруулаад)
- Ойн салбарын хуулийн хэрэгжилтийн хангах, засаглал ба худалдаа, Сайн дурын хамтын ажиллагааны гэрээ , Ойн модны аж ахуйн хууь ёсны шалгуурыг баталгаажуулах систем (Timber Legality Assurance Systems)
- Гомдол барагдуулах механизм
- Кадастрын мэдээллийн сан
- Ойн тогтвортой менежментийг үнэлэхэд ашигладаг мэдээллийн эх үүсвэрүүд
- Орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн бүртгэл
- Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай ОУ-ын Конвенцийг хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай үндэсний стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Бусад олон улсын конвенцуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөрүүд

Монгол Улсад ашиглаж болох мэдээллийн эх үүсвэрүүдийн жишээ

- Ойн зохион байгуулалтын мэдээ, тайлан (ОСХТ)
- Хортон шавжтай тэмцэх ажлын мэдээ (ОСХТ)
- Байгаль орчны мэдээллийн сан /газрын доройтол, усны эх үүсвэрийн мэдээ/ (БОМТ)
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар (ГХГЗЗГ)
- REDD+-ийн хүрээнд боловсруулах Үндэсний ойн мониторингийн систем
- Үндэсний тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой мэдээллийн сан (ҮСГ)
- Үндэсний статистикийн газрын мэдээллийн сан, жилийн тайлан
- Гомдол барагдуулах механизм (уул уурхайд г.м)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан
- Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай ОУ-ын Конвенцийг хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлагнах механизм
- НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Цөлжилт, газрын доройтолтой тэмцэх үндэсний стратеги

Мэдээллийн төрөл, давтамж

- Хамгийн чухал гэж үзсэн мэдээллийн систем болон эх үүсвэрүүдийг үнэлнэ /тусгай маягтын дагуу/:
 - Ямар төрлийн мэдээлэл, статистик, орон зайн дүн шинжилгээний мэдээлэл цуглуулдаг
 - Мэдээлэл цуглуулах давтамж, агуулга, цар хүрээ, тогтмол шинэчлэгддэг эсэх? Бүх аймгийг хамардаг уу?
 - Энэ мэдээлэл нь СНСМС-ийн мэдээллийн хэрэгцээтэй хэр нийцэж чадах вэ?
 - Мэдээтэй холбоотой сул тал, бэрхшээл , тухайлбал “албан ёсны”, найдвартай мэдээ байж чадах эсэх гэх мэт
 - Мэдээллийн системийг ажиллуулахтай холбоотой институцын чадавх, хүчин зүйлс
- Зарим жишээг харуулна. Дараа нь Амармаа өнөөг хүртэл хийсэн ажлын явцыг танилцуулна.

Бүтэц ямар байхыг харуулсан жишээ

СНСЗ-ын бүрэлдэхүүн хэсэг	Мэдээллийн хэрэгцээ	Мэдээллийн эх үүсвэр				Санал
СНСЗ-ыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох, холбогдох БХЖ	СНСЗ-ын хэрэгжилтийн байдлыг харуулахын тулд ямар мэдээллийг СНСМС-д оруулах нь зүйтэй вэ?	Одоогоор ямар нарийвчилсан мэдээлэл олж болохоор байна вэ? (Одоо байгаа юу, эсвэл цаашид бүрдүүлэхээр төлөвлөж байна уу?)	Энэ нь ямар төрлийн мэдээлэл вэ? (Жнь, статистикийн мэдээ, орон зайн мэдээ, газрын зураг уу?)	Тухайн бэлэн байгаа мэдээллийг хаанаас авч болох вэ? Олж авахад хялбар уу?	Мэдээллийн давтамж, түвшин, хэмжих нэгж нь ямар вэ? (Жнь, мэдээлэл цуглуулах, шинэчлэх давтамж ямар байдаг вэ? Захиргааны ямар түвшинд, ямар хэмжих нэгж ашигладаг г.м. Тухайлбал, га, тохиолдол, сум, тосгонд г.м)	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тулгарах бэрхшээл болон бусад чухал асуудлууд

Бусад улсын жишээнээс: СНСЗ Е-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг буюу элементийн дагуу ажилласан байдал

ОУ-ын удирдамжид заасан го асуудал	Мэдээллийн систем, эх үүсвэр (вэб холбоос)	Одоогийн байгаа холбогдох үзүүлэлт, мэдээллийн сангийн мэдээ (давтамж, нэгж, жилийн, аймгийн түвшинд, га-гаар хэмжих г.м)	Цаашид ашиглах, холбогдох төлөвлөсөн мэдээлэл байна уу?	Сул тал, бэрхшээл, санал
[REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг таримал ой болгон хувиргахад ашиглахгүй байх	Ойн нөөцийн хяналтын систем(www.frms.org)	<p>Байгалийн ойн бүрхэвчийн өөрчлөлт (% / га), жилд</p> <p>Байгалийн ойн чанарын өөрчлөлт (сул-дунд-их, м³/га), жилд, ойн төрлөөр, зохион байгуулалтын ангилалаар</p> <p>Газар ашиглалтын өөрчлөлт (га-р), өөрчлөлтийн хэв шинж (хөдөө аж ахуй, барилга г.м), жилд</p> <p>Ойн ангиллын өөрчлөлт (га-р) (хамгаалалтын ойгоос үйлдвэрлэлийн ашиглалтын ойл шилжсэн г.м), жилд</p>	Мэдээллийг 2016 оноос цуглуулсан, 2018 он гэхэд бүх ой бүхий аймгуудыг хамруулахаар зорьж байна	БОАЖЯ-ны тоо баримттай зөрж магадгүй , аль нь албан ёсны болохыг нягтлах шаардлагатай
	REDD+ портал	Байхгүй	<p>Ойн бүрхэвчийн өөрчлөлтийг харуулсан зургийг үндэсний болон ой бүхий аймаг бүрээр гаргана</p> <p>Ойн ангиллын өөрчлөлтийг харуулсан хүснэгт гаргана (га/жил-ээр)</p> <p>Ойн хомсдол, ойн доройтол, ойн ургалтыг харуулсан зураг гаргана</p>	Портал сайтны хуваарь нь тодорхой бус, ойн нөөцийн мониторингийн системээс энэ мэдээллийг авна.

Мэдээллийн үнэлгээг ашиглах нь

- СНСМС-д ашиглаж болохоор ямар мэдээлэл бэлэн байна вэ?
- Ямар мэдээлэл дутагдаж байна, тэр мэдээллийг яаж олох вэ?
- СНСМС-ийг хаана байршуулах, аль байгууллага ажиллуулах зэрэг институцын зохион байгуулалт нь ямар байх вэ?